



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2015 оны 09 сарын 28 өдөр

Дугаар А/58

Улаанбаатар хот

Хяналт, шалгалтын
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, газрын зөвлөлийн хурлын 2015 оны 09 сарын 10-ны өдрийн хурлын тэмдэглэл, байгууллагын үйл ажиллагааг идвэхжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг идвэхжүүлэх, ажилтан албан хаагчдын ажлын цагийн үр бүтээлийг өндөржүүлэх, нийслэлийн засаг захиргааны зургаан байруудын үйлчилгээ, техникийн ажиллагааг сайжруулах, үйлчлүүлэгч байгууллагуудын ажлын тав тухыг бүрдүүлэх зорилгоор байгууллагын хяналт, шалгалт явуулах байнгын ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Үүнд:

АЖЛЫН ХЭСГИЙН АХЛАГЧ:

Ч.БАТ-ЭРДЭНЭ

Дотоод хяналт хариуцсан ажилтан

ГИШҮҮД:

Н.ЭНХЗАЯА

Их эмч

Д.ОЧИРБАТ

Тооцооны нягтлан бодогч

Д.САЙНЗАЯА

Үйлчилгээний ахлах ажилтан

Ч.ДАРИЙМАА

Жолооч

2. Хяналт, шалгалтын ажлын хэсэг нь үйл ажиллагааны төлөвлөгөөтэй, санал санаачлагатай ажиллаж, улирал бүр ажлын тайлангаа газрын удирдлагад танилцуулж ажиллахыг Ажлын хэсгийн ахлагч /Ч.Бат-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

ДАРГА  Ш.ОДОНЧИМЭГ



1150500567